



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/692

Булган сум

Г Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
нэр өөрчлөх тухай Г


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын "Төрийн өмчит компани байгуулах тухай" 2021 оны 394 дүгээр тогтоол, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.1.3.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын алба" ТӨҮГ (6528627)-ын Булган салбарын эзэмшиж буй Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржавын 4 дүгээр гудамж 405 тоотод байршилтай 6308003544 нэгж талбарын дугаартай үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалттай 28923 м<sup>2</sup> газрын хуулийн этгээдийн нэрийг "Хөдөө, аж ахуйн корпораци" ТӨХХК болгон өөрчилсөнтэй холбогдуулан газар эзэмших гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т зөвшөөрсүгэй.

2. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэн "Хөдөө, аж ахуйн корпораци" ТӨХХК (Б.Ариунбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/373 дугаар захирамжийн "Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын алба" ТӨҮГ-тай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ